



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.06.09 № 03/51 ЧАТ/САТ/2014/30 НТТ

Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн яам 2003 онд Баруун 5 аймагтай 15 жилийн хугацаатай 5,564,741,812.23 төгрөгийн, Зүүн болон төвийн бүсийн 8 аймагтай 25 жилийн хугацаатай 19,382,869,200.00 төгрөгийн дамжуулан зээлийн гэрээг тус тус байгуулж санхүүгийн тайланд харилцагч тус бүрээр тайлагнаагүй, зарим аймагтай тооцоо нийлээгүй, тооцоо нийлсэн нь зөрүүтэй, тайлан тэнцэлд гэрээний дүнгээс 15,129,868,081.68 төгрөгөөр илүү тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2, 7.1, 9.1 дэх заалтуудтай зөрчилдөж, 2003 онд байгуулсан "дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний холбогдох заалтууд биелэгдэхгүй төлбөр төлөх хугацаа 4-10 жилээр тус тус хэтэрсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ НЬ**:

Дээрх дамжуулан зээлдүүлэлтийн авлагыг харилцагч тус бүрээр бүртгэн үлдэгдлийг баталгаажуулж, үр дүнг тооцон, санхүүгийн тайланд гэрээний дүнгээс 15,129,868,081.68 төгрөгөөр илүү тусгасан байгаа зэрэгт шийдвэрлэх арга хэмжээ авч биелэлтийг 2014 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Б.Нямаа нарт даалгав.

АУДИТОР



Б.СЭРЖМЯДАГ